

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЦОГТГЭРЭЛ

2024 оны 03 сарын өдөр

**МОНГОЛ ОРНЫ ТӨВИЙН БҮС НУТГИЙН ХАРЬ ЗҮЙЛ УРГАМАЛ, АМЬТАНЫ
СУДАЛГАА ХИЙХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1	Ажлын үндэслэл	<p>Куньмин-Монреалын “Дэлхийн биологийн олон янз байдлын хамрах хүрээний зорилтын нэгт улс орон болгон өөрийн оронд тархсан харь зүйлийн хяналтыг тогтоох гэж заасан. Харь зүйл амьтан, ургамлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор зориудаар болон санамсаргүйгээр зөөвөрлөгдөн ирж нутагших харь зүйлийн бүртгэл хөтлөх, харь зүйл амьтан, ургамлыг судлах, түрэмгийлэгч харь зүйлийг тодорхойлох, устгах зэрэг үйл ажиллагааг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Мөн Биологийн олон янз байдлын тухай конвенцыг хэрэгжүүлэх Үндэсний тавдугаар тайланд харь зүйлийн асуудлыг анхаарах шаардлагатай байгааг зөвлөжээ. Харь зүйлийг судлах гол зорилго нь тэдгээрийн байгаль, тухайн экосистемийн идэш тэжээлийн хэлхээнд үзүүлэх үүрэг, ач холбогдлыг тодруулах улмаар нутгийн биологийн олон янз байдалд нөлөөлөх нөлөллийг илрүүлэх, харь зүйлийн шилжин орж ирэх коридорыг илрүүлэх, экосистемд тархах хурдыг тодорхойлох, түрэмгийллийг урьдчилан тооцоолох, хянах, урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээг боловсруулахад чухал ач холбогдолтой юм.</p>
2	Зорилго	<p>Монгол орны төвийн бүс болон Бөхөн шарын нуруу, тарвагтайн нуруунд тархсан харь зүйл амьтан, ургамлын жагсаалтыг шинэчлэх, тархац, нөөцийн талаар мэдээллийн сан үүсгэх, харь зүйл ургамал ашиглах журмын төсөл боловсруулж, холбогдох талуудад зөвлөмж хүргүүлэх.</p>
3	Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ	<p>Монгол орны төвийн бүсийн (Бөхөн шарын нуруу, Тарвагтайн нуруу) тархсан харь зүйл амьтан, ургамлыг илрүүлж, түрэмгийлэгч харь зүйлийн төлөв байдлыг тодорхойлох, амьтнаас 20, ургамлаас 50 зүйлийг сонгон биологи, экологийн онцлогийг тодруулах, түрэмгийлэгч харь зүйлээр мэдээлэл бэлтгэх. Цаашид бодлогын хэмжээнд авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах.</p>
4	Ажил гүйцэтгэх хугацаа	<p>Зөвлөх үйлчилгээний ажлыг 6 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.</p>
5	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">Монгол орны төвийн бүсэд (Бөхөн шарын нуруу, Тарвагтайн нуруу) тархсан харь зүйл амьтан, ургамлыг илрүүлэх зорилгоор хээрийн /тариалангийн газар/, болон суурин судалгаа хийн жагсаалт гаргах;

		<ul style="list-style-type: none"> • Хот суурин газарт харь зүйл ургамлыг хяналтгүй тархахаас сэргийлж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглаж буй харь зүйлийн хүнсний, таримал, гоёл чимэглэлийн мод, сөөг, цэцэг, зүлэг зэргийг тодруулж, жагсаалт гаргах; • Түрэмгийлэгч харь зүйл амьтан, ургамлын зүйлийн олон янз байдлыг ургамлын мужлал, гарал үүсэл, Монгол оронд бүртгэгдсэн он цаг, хэрэглээгээр ангилах; • Харь зүйл амьтан, ургамлын, тархцын талаар мэдээллийн сан үүсгэх, зураглах; • Манай оронд тархсан харь зүйл амьтан, ургамлын зүйлүүдийн хэрэглээ, ашиглалт, аюул занал, түрэмгийлэгч харь зүйлээс сэргийлэх талаар зөвлөмж бэлтгэх; • Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон хорио цээртэй хөнөөлт организмын жагсаалтад бүртгэгдсэн зүйлээс дотоодод илэрсэн зүйлээр зөвлөмж бэлтгэх; • Цаашид бодлогын хэмжээнд авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах; • https://griis.org/ дэлхийн сайтад байгаа Монгол орны харь зүйл ургамлын жагсаалтыг шинэчлэх, байгаль орчны мэдээллийн сан /www.eic.mn/-д оруулах; • Харь зүйл ургамал ашиглах журмын төсөл боловсруулж, хэлэлзүүлэх.
6	Тайлагналт	<p>Эхлэлийн тайлан: Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулсанаас ажлын 10 хоногт гэрээт ажил гүйцэтгэх арга зүй, нарийвчилсан төлөвлөгөөг захиалагчид хүргүүлж батлуулсан байна;</p> <p>Явцын тайлан: Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулсанаас 2 сарын дотор явцын тайланг гэрээ байгуулагч талд хүргүүлсэн байна;</p> <p>Эцсийн тайлан: Зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн тайланг гэрээ байгуулсанаас 6 сарын дотор гэрээ байгуулагч талд ирүүлсэн байна.</p>
7	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчид тавигдах шаардлага	<p><u>Байгууллагад тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээ үзүүлэх байгууллага нь 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай хуулийн этгээд байх ба 3-аас доошгүй орон тооны мэргэжлийн судлаачидтай байх; • Үйлчилгээний өдөр тутмын ажил болон тус ажлыг хянан хариуцан ажиллах мэргэжилтэй байх; • Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын шаардлага, дүрэм журмыг мөрдлөг болгон ажилладаг байх, (ILO стандартууд, хөдөлмөрийн мөлжлөг, тэвчишгүй хөдөлмөр эрхлэх, аливаа хүчирхийлэл гэх мэт); • Амьтан, ургамлын ангилал зүйн судалгаа хийдэг эдгээр чиглэлээр мэргэшсэн, ижил төстэй төслүүдэд ажиллаж байсан туршлага бүхий 4-өөс доошгүй зөвлөхтэй байх, зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна Үүнд: <p><u>Зөвлөх багт тавигдах шаардлага:</u></p> <p>1. Багийн ахлагч нь амьтан, ургамлын ангилал зүйн чиглэлийн аль нэгээр мэргэшсэн, харь зүйлийн чиглэлээр</p>

		<p>ажиллаж байсан ажлын туршлагатай, докторын зэрэгтэй байх;</p> <p>2. Багийн гишүүд нь ижил төстэй төслүүдэд ажиллаж байсан туршлагатай ургамал, амьтны судалгаа хийдэг, мэргэшсэн байх;</p> <p>3. Судалгааны ажлыг хүлээгдэж буй үр дүнд нийцүүлэн тогтоосон хугацаанд гүйцэтгэн, тайланг захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.</p>
8	Захиалагч байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Монголын унаган байгалийн хүлцэл тогворжилтыг хангах нь” МОН/19/301 төсөл
9	Хүрэх үр дүн	<ul style="list-style-type: none"> • Монгол орны төвийн бүсэд (Бөхөн шарын нуруу, Тарвагтайн нуруу) тархсан харь зүйл амьтан, ургамлын жагсаалт гаргасан байна; • Цэцэрлэгжүүлэлтэд ашиглаж буй харь зүйлийн хүнсний, таримал, гоёл чимэглэлийн мод, сөөг, цэцэг, зүлэг зэргийг тодруулж, жагсаалт гаргасан байна; • Түрэмгийлэгч харь зүйл амьтан, ургамлын зүйлийн олон янз байдлыг ургамлын мужлал, гарал үүсэл, Монгол оронд бүртгэгдсэн он цаг, хэрэглээгээр ангилсан байна; • Манай оронд тархсан харь зүйл амьтан, ургамлын зүйлүүдийн хэрэглээ, ашиглалт, аюул занал, түрэмгийлэгч харь зүйлээс сэргийлэх талаар мэдээлэл бэлтгэх; • Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон хорио цээртэй хөнөөлт организмын жагсаалтад бүртгэгдсэн зүйл байгаа эсэхийг тодруулж, мэдээлэл бэлтгэсэн байна; • Цаашид бодлогын хэмжээнд авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулсан байна; • https://griis.org/- дэлхийн сайтад байгаа Монгол орны харь зүйл ургамлын жагсаалтыг шинэчилсэн байна; • Харь зүйл ургамал ашиглах журмын төсөл боловсруулж, хэлэлцүүлсэн байна.
10	Хүлээн авах материал	Тайланг хэвлэмэл 3 хувь болон электрон файлууд (флаш диск) байна.
11	Санхүүжилтийн эх үүсвэр	Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламж
12	Төсөвт өртөг	34,700,000 (гучин дөрөв сая долоон зуун мянга) төгрөг

